

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
(2022 оны эхний хагас жил)

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

Улаанбаатар хот

2022.06.16

Д/д	Зорилт (бодлогын үндэслэл)	Төсөл, арга хэмжээ	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Шаардла- гатай нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг), эх үүсвэр	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр)			Хэрэгжилтийн явц, хэрэгжилтийн хувь
						Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая төгрөг)	Төс- вийн гүйцэт- гэл (сая төгрөг)	
1	2	3	4	5	6	7	8	9	10

Бүлэг 4. Засаглалын бодлого

Зорилго 4.1. Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.

4.1.19	МУТЖУЧ- 5.1.1, ЗГУАХ- 4.4.10	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	46.0 Улсын төсөв	Хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулсан. Холбогдох судалгаа хийгдсэн. Төрийн өмчит компанийн засаглалын дундаж үнэлгээ 53.9 хувь.	Хууль батлагдсан байна. 3 журмын төслийг баталж мөрдүүлсэн байна. Компанийн засаглалын дундаж үнэлгээ 65-70 хувьд хүрсэн байна.	-	-	ТӨБЭГ-ын 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А-1/362 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох судалгааг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн дахин боловсруулж, судалгааг шинэчлэн холбогдох баримт материалын хамт хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт хүргүүлсэн. 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдөр ХЗДХЯ-нд хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын
--------	---------------------------------------	--	---	---------------------	---	---	---	---	---

<p>хэсэг 2022 оны эхний хагас жилд 5 удаа хуралдаж, хэлэлцүүлгээс гаргасан санал болон яамд, аймаг, орон нутгаас ирүүлсэн саналыг төсөлд тусган Засгийн газрын 05 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Хуралдаанаас хуулийн төсөлд зэрчмын зөрүүтэй санал гарсан тул дэмжихээс татгалзаж хойшлуулсан.</p>	<p>Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төслийг ХЗДХЯ-аас боловсруулж Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд УИХ-д өргөн барихыг дэмжсэн. Уг хуулийн төслийг 05 дугаар сарын 04-ний өдөр УИХ-д өргөн барьж, Эдийн засгийн Байнгын хорооны хурлаас УИХ-аар хэлэлцүүлэхээр дэмжсэн. УИХ-ын 06 дугаар сарын 09-10-ны өдрийн нэгдсэн чуулганаар Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэх эсэхийг хэлэлцээд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шийдвэрлэсэн.</p> <p>Хуулийн төсөл одоогоор батлагдаагүй тул дагалдан гарах дүрэм, журам батлагдаагүй болно.</p> <p>УИХ-ын 2022 оны 16 дугаар тогтоолоор төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийг баталсан. Уг үндсэн чиглэлийн хүрээнд төрийн өмчит хуулийн этгээдийг олон нийтийн хяналтад оруулах, санхүүгийн сахилга</p>
--	--

												бат, засаглалыг сайжруулах, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангах зорилгоор төрийн өмчит нэр бүхий 25 компанийн 34 хүртэлх хувийн хувьцааг, Төрийн банкны нийт хувьцааны 20 хүртэлх хувийг тус тус нээлттэй арилжихаар шийдвэрлэсэн. 2022 оны компанийн засаглалын үнэлгээ 69.0 хувьтай байна.	Биелэлт 90.0 хувь
Зорилго 4.4. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хууль ёсыг бэхжүүлнэ.													
4.4.1	5.2.19, МУТЖҮЧ- 5.1.1, ЗГҮАХ- 4.4.10	Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэл хийж, хяналт тавих	Ерөнхий сайд	25.0 Улсын төсөв	2016 онд улсын үзлэг, тооллого зохион байгуулсан.	Улсын үзлэг, тооллого зохион байгуулсан байна.	301.0	141.0				Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолд нийцүүлэн ТӨБЗГ-ын 2022 оны 64 дүгээр тогтоолоор улсын үзлэг, тооллогын ажлыг удирдан зохион байгуулах төв комиссын бүрэлдэхүүн, журам, маяг, заавар, арга зүйг баталсан. Тооллогын ажлын журам, заавар, маягт холбогдох бусад баримтыг нэгтгэн гарын авлага боловсруулж, 6300 хувь хэвлүүлэн ТӨБЗГ, нийслэл Өмчийн харилцааны газар, 21 аймгийн Орон нутгийн өмчийн газраар дамжуулан үзлэг тооллогод хамрагдах бүх байгууллагад хүргүүлэв. Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг эхлүүлж, ТӨБЗГ-ын даргын 2022 оны Б/20 дугаар тушаалаар нийслэл, 21 аймагт холбогдох арга зүйн сургалт, семинарыг зохион байгуулж, удирдамжаар ханган ажиглаж байна. Улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах	

											<p>асуудлаар арга зүйн болон программ хангамжийн сургалтыг 21 аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтнүүдэд 3 удаа цахим хэлбэрээр, Улаанбаатар хот дахь байгууллагуудыг хамруулан танхимын хэлбэрээр тус тус зохион байгуулсан.</p> <p>ТӨБЗГ-ын Ажлын хэсгээс 2022 оны 4 болон 5 дугаар сард нийслэл, 21 аймаг ажиллаж, улсын үзлэг, тооллогод хамрагдах байгууллагын холбогдох албан хаагчдэд уг ажилд ашиглагдах програм хангамжийн болон тооллогын арга зүйн сургалтыг хийсэн.</p> <p>Улсын үзлэг тооллогыг зохион байгуулахад шаардлагатай нийт 301.0 сая төгрөгийн төсөв 2022 оны улсын төсөвт тусгагдан батлагдсан болно. Үүнээс 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар, тооллогын мэдээллийн системийн техник хангамжийн асуудлыг холбогдох хуулийн дагуу нээлттэй сонгон шалгаруулалтын журмаар худалдан авсан бөгөөд сургалтын зардал орсон дүнгээр нийт 141.0 сая төгрөгийг зарцуулсан.</p> <p>Astvision ХХК-тай хамтарч улсын үзлэг, тооллого, өмчийн бүртгэлийн програм хангамжийг хөгжүүлж, туршин ашиглаж байна.</p> <p>www.buildei.pcsv.gov.mn веб хуудсыг тооллогын програмтай холбож, сургалтад ашигласан бөгөөд шаардлагатай асуудлаар нэмэлт зөвлөмж, мэдээлэл байршуулан мэдээлж, foollogo@pcsp.gov.mn цахим</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	---

												шуудангаар холбогдох санал хүсэлт, гомдол, асуулт зэргийг хүлээн авч, хариулт өгч байна. Биелэлт 70.0 хувь
Дундаж үнэлгээ “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 80.0 хувь байна.												

Товчилсон үгийн жагсаалт:

МУТЖҮЧ Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
 ЗГҮАХ Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
 ТӨБЭГТ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

Танилцсан:
**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН
 ГАЗРЫН ДАРГА**

Б.ЦЭНГЭЛ

Хянасан:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА


Н.ГАНБОЛД

Нэгтгэн боловсруулсан:
**ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ТОГТООЛ ШИЙДВЭРЧИЙН
 БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН**

Х.ЭНХЧИМЭГ

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:
**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
 АУДИТЫН МЭРГЭЖИЛТЭН**

Д.ЦЭРЭНЛХАМ



Х.Энхчимэг
 2024.06.16

Д.Цэрэнлхам